

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 24 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2024-03

Улаанбаатар хот

2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2023 оны үйл ажиллагааны тайлан ("2023 оны үйл ажиллагааны тайлан")-г хянан хэлэлцээд 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн R-2024-12 тоот тогтоол гарган, 2023 оны үйл ажиллагааны тайлан нь Банкны үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв бөгөөд бодитоор илэрхийлсэн гэж дүгнэж ("ТУЗ-ийн дүгнэлт"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
- Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурал хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

- Энэхүү тогтоолын хавсралт ёсоор Банкны 2023 оны үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА